

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

***/ДУЛААНЫ СТАНЦЫН АЖЛЫН ЯВЦ, ГЭРЭЭНИЙ
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН/***

2018 он

Агуулга

1. Аудитын нэр
2. Аудитын код
3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх
4. Аудитын зорилт
5. Аудитад хамрах хүрээ
6. Аудитын арга
7. Эрсдлийн үнэлгээ
8. Шалгуур үзүүлэлт
9. Аудит хийх багийн үнэлгээ, хугацаа
10. Аудитын тайлан

Хавсралт -Арга зүй
-Асуудлын шинжилгээ
-Эрсдлийн үнэлгээ
-Хөтөлбөр

БАТЛАВ.

АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2018.06.04.

Булган

1. Аудитын нэр:

Булган аймгийн Дулааны станцын ажлын явц, гэрээний хэрэгжилт, үр дүн.

2. Аудитын код:

БуТАГ-/2018/-НА-03

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аймгийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилт:

Аудитын зорилт нь Дулааны станцын ажлын явц, гэрээний хэрэгжилт, үр дүн, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зарцуулалт, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтанд тавих дотоодын хяналтыг хэрхэн үр ашигтайгаар хэрэгжүүлж ямар үр нөлөөтэй ажилласанд дүгнэлт өгч шаардлагатай бол санал боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтнаар шийдвэрлүүлэхэд оршино.

- Дулааны цахилгаан станцын ажлын явц үр дүн,
- Дулааны цахилгаан станцын гэрээний хэрэгжилт,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зарцуулалт, үр дүн,
- Орон нутгийн оролцоо, хөрөнгө оруулалтын явц, үр дүн,
- Төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт,
- Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт,

5. Аудитын хамрах хүрээ:

Булган аймгийн Дулааны станцын ажлын явц, гэрээний хэрэгжилт, улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтсийн бодлогын хэрэгжилт, аймгийн ГХБХБГ- аас гэрээний дагуу хийсэн хяналт үр дүнг хамруулна.

6.Аудитын арга

Аудитын явцад аудитын олон улсын стандарт, төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох асуудлаар аудитад хамрагдсан төсөвт байгууллагын ажилтнуудаас асуулга авах, судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

7. Эрсдлийн үнэлгээ

Булган аймгийн Дулааны станцын ажлын явц, гэрээний хэрэгжилт, улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнг “Дунд” гэж үзлээ.

8.Шалгуур үзүүлэлт

- Төрийн аудитын тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Засгийн газрын холбогдох тогтоол шийдвэрүүд, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм журам
- Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоол,
- Гэрээний биелэлтийг тооцох
- Холбогдох бусад хууль, тогтоомж

9. Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Аймгийн төрийн аудитын газрын даргын удирдамжаар аймгийн Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр удирдаж, менежер Ж.Энхцоодол хяналт тавьж ахлах аудитор Г.Ганбаатар, аудитор Х.Баттулга нар 2018 оны 06 дугаар сарын 06-наас эхлэн ажлын 24 хоногт багтаан удирдамжийн дагуу явуулна.

10.Аудитын тайлан

Аудитын тайлан нь энгийн, тодорхой, хоорондийн уялдаа холбоотой байх бөгөөд ерөнхий зүйл, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, байгууллагуудын дарга, эрхлэгч нарын санал болон хавсралт судалгаа тооцоо, тайлбаруудаас бүрдэнэ.

Аудитын тайлангийн төслийг шалгаагдагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авч аудитын удирдагчид танилцуулан баталгаажуулна.

ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

Г.ГАНБААТАР